



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/426

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн паркийн усан тоглоомын засвар /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгч “Хөшөөт өндөр цахир” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

З.Өмиртай - Аймгийн ерөнхий архитектор бөгөөд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: М.Нансалмаа - Шим ус орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Ш.Бахыт - Хүүхдийн паркийн инженер

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэбат - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

2. Хүүхдийн паркийн усан тоглоомын засвар /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгч “Хөшөөт өндөр цахир” ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /З.Өмиртай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН